



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 516

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 16,181,818.00 (арван зургаан сая нэг зуун наян нэгэн мянга найман зуун арван найман) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Ус цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, урьдчилан мэдээлэх хэлтсийн дарга Л.Оюунжаргал, Ховд аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга А.Энхзаяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 10 дугаар сарын-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

Ховд аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Үйлдвэрлэсэн огноо | Балансын үнэ (төгрөг) | Хуриртлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) | ТӨБЗГ-ын 2022 оны 424 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг) | Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг) |
|----------|---|--------------------|--|--|----------------------|--|--|
| 1 | Ланд круйзер-80 00-46 ХОУ HDJ810067167 | 1996/2004 | 16,181,818 | 16,181,818 | 0.00 | 9,500,000.00 | 4,750,000.00 |
| Нийт дүн | | | 16,181,818 (арван зургаан сая нэг зуун наян нэгэн мянга найман зуун арван найман) | 16,181,818 (арван зургаан сая нэг зуун наян нэгэн мянга найман зуун арван найман) | (тэг) | 9,500,000.00 (есөн сая таван зуун мянга) | 4,750,000.00 (дөрвөн сая долоон зуун тавин мянга) |